

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ 2016 ОН ХҮРТЭЛ БОЛОВСРОНГҮЙ
БОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2013 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн
Ж.БАТЗАНДАН**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгүй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Үндсэн чиглэлийн төсөлд “хуулийн төсөл”, “Улсын Их Хурлын тогтоол”-ын төсөл гэсэн 2 үндсэн хэсэг, “Монгол Улсын Ерөнхийлөгч”, “Улсын Их Хурлын гишүүн”, “Засгийн газар”-аас санаачлан боловсруулах гэсэн 3 хэсэгт ангилсан бөгөөд Засгийн газраас санаачлан боловсруулах хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын гишүүдийн эрхлэх асуудлын хүрээгээр 19 чиглэлд ангилж, хууль болон Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага, өргөн мэдүүлэх хугацаа, хяналт тавих Байнгын хороо зэргийг тодорхой тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар үндсэн чиглэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Баярцогт, З.Энхболд нар Засгийн газрын мөрийн хөтөлбөрт суурилсан үндсэн чиглэлийг батлах ёстой бөгөөд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд үндсэн чиглэлийг баталдаг байхаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлахаар бол үндсэн чиглэлд оруулахгүйгээр бүрэн эрхийнхээ дагуу хууль санаачлах эрхтэй, Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүдийн санаачлах хуулийг үндсэн чиглэлд тусгах нь тогтоолын хэрэгжилтэнд нь хяналт тавих, хариуцлагын асуудал ярих боломжгүй болох тул Засгийн газрын санаачлан боловсруулах хуулийн төслийг л үндсэн чиглэлд тусгах мөн өргөн мэдүүлсэн хууль санаачлагч гэдэг хүснэгтэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийг тавих шаардлагагүй зэрэг саналуудыг тус тус гаргасан болно.


Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгүй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ш.ТҮВДЭНДОРЖ